



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/155/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг: Munkhzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	14
Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа зөрчил гараагүй.	14
4.2 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Сандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Аудитын гэрчилгээ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.21 № 49

танай _____-ны № _____-т

ХАРХОРИН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ш.БОЛОРМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь үйл ажиллагааны үндсэн данснаас 1045.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43-р тогтоол зөрчин тавилга эд хогшил худалдаж авсан мөн уралдаан тэмцээнд 500.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

015030097

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,734,292.00	7,379,392.00
33	АВЛАГА	-	39,900.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		39,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,734,292.00	7,339,492.00
351	Түүхий эд материал	1,043,545.00	688,392.00
35110	Тусгай зориулалттай материал	1,043,545.00	688,392.00
354	Хангамжийн материал	4,690,747.00	6,651,100.00
35410	Бичиг хэргийн материал		233,500.00
35420	Аж ахуйн материал	347,900.00	521,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,800,000.00	4,414,000.00
35440	Түлш, шатах тослох материал	308,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	234,847.00	1,482,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	54,429,866.60	113,887,713.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	54,429,866.60	113,887,713.34
392	Биет хөрөнгө	54,429,866.60	113,887,713.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	35,000,000.00	35,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 641,666.69	- 4,141,666.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	88,430,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 23,611,110.96	- 28,470,555.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,120,476.00	27,178,376.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 4,522,435.40	- 8,854,303.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,660,642.66	6,574,037.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 600,039.01	- 1,828,175.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,000.00	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	60,164,158.60	121,267,105.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	60,164,158.60	121,267,105.34
51	Засгийн газрын хувь оролцоо	60,164,158.60	121,267,105.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	29,646,566.00	29,646,566.00
512	Хуримтлагдсан үр дүн	29,282,511.45	90,385,458.19
51210	Өмнөх үеийн үр дүн	29,282,511.45	29,282,511.45
51220	Тайлант үеийн үр дүн		61,102,946.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,235,081.15	1,235,081.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	60,164,158.60	121,267,105.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	164,968,918.66	210,507,530.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,767,618.66	47,467,930.04
120	Нийтлэг татварын бус орлого	41,767,618.66	47,467,930.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,760,000.00	47,467,930.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,760,000.00	47,467,930.04
120009	Бусад орлого	2,007,618.66	-

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	123,201,300.00	163,039,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,201,300.00	163,039,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,201,300.00	163,039,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	113,909,565.77	139,146,846.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,909,565.77	139,146,846.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,719,222.20	132,734,709.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,509,527.00	75,485,798.00
210101	Үндсэн цалин	72,509,527.00	55,408,231.00
210104	Урамшуулал		20,077,567.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,877,414.19	10,026,849.62
210201	Тэтгэврийн даатгал	6,199,029.84	7,098,311.28
210202	Тэтгэмжийн даатгал	729,295.28	800,864.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	580,076.20	623,891.76
210204	Ажилгүйдлийн даатгал	119,669.67	121,786.70
210205	Эрүүл мэндийн даатгал	1,249,343.20	1,381,995.26
2104	Хангамж, бараа материалын зардал	7,867,131.00	10,168,150.00
210401	Бичиг хэрэг	1,588,713.00	1,424,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,850,000.00	6,671,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	381,531.00	1,380,700.00
210404	Ном, хэвлэл	46,887.00	495,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		195,200.00
2105	Нормативт зардал	50,000.00	469,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	469,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,704,100.00	4,946,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	562,100.00	-
210604	Урсгал засвар	4,142,000.00	4,946,500.00
2107	Томилолт, зочны зардал	694,000.00	970,000.00
210702	Дотоод албан томиллолт	694,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,488,978.00	162,115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,330,138.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	136,840.00	-

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	16,615.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,528,072.01	30,505,896.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	571,231.00	9,244,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,371,500.00	6,096,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,585,341.01	15,165,246.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,190,343.57	6,412,137.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	1,368,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	1,368,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,810,343.57	5,043,537.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,810,343.57	5,043,537.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	51,059,352.89	71,360,683.57
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	10,257,736.83
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	10,257,736.83
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
4		-	10,257,736.83
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	51,059,352.89	61,102,946.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	123,201,300.00	163,039,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	123,201,300.00	163,039,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,201,300.00	163,039,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,201,300.00	163,039,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	109,296,900.00	125,626,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,296,900.00	125,626,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,106,556.43	119,214,562.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,239,394.00	75,433,737.00
210101	Үндсэн цалин	50,605,038.00	55,356,170.00
210104	Урамшуулал	21,634,356.00	20,077,567.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,942,322.43	10,118,810.62
210201	Тэтгэврийн даатгал	6,265,900.63	7,170,581.37
210202	Тэтгэмжийн даатгал	729,350.95	796,337.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	580,067.40	630,349.18

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	120,623.39	123,401.27
210205	Эрүүл мэндийн даатгал	1,246,380.06	1,398,141.54
2104	Хангамж, бараа материалын зардал	7,583,000.00	9,180,900.00
210401	Бичиг хэрэг	1,025,000.00	996,700.00
210402	Тээвэр, шатахуун	6,158,000.00	6,253,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	320,000.00	1,308,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	448,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,000.00	174,600.00
2105	Нормативт зардал	20,000.00	469,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,000.00	469,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,222,500.00	5,976,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	632,500.00	954,000.00
210604	Урсгал засвар	7,590,000.00	5,022,500.00
2107	Томилолт, зочны зардал	694,000.00	970,000.00
210702	Дотоод албан томилолт	694,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,642,240.00	162,115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,483,400.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	136,840.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	16,615.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,763,100.00	16,903,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	963,100.00	10,633,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,800,000.00	6,270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,190,343.57	6,412,137.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	1,368,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	1,368,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,810,343.57	5,043,537.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,810,343.57	5,043,537.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,904,400.00	37,412,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,904,400.00	37,412,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,904,400.00	37,412,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,904,400.00	37,412,900.00
223001	Бусад хөрөнгө	13,904,400.00	37,412,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	13,904,400.00	37,412,900.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	128,380.20		128,380.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	128,380.20	-	128,380.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	128,380.20	-		128,380.20
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	61,102,946.74		61,102,946.74
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	128,380.20	61,231,326.94	-	61,102,946.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	123034800.00	117390956.43	163039600.00	157996062.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123034800.00	103486556.43	163039600.00	120583162.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	122654800.00	103106556.43	161671000.00	119214562.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	75606900.00	72239394.00	79532400.00	75433737.00
210101	Үндсэн цалин	55522200.00	50605038.00	59447700.00	55356170.00
210104	Урамшуулал	20084700.00	21634356.00	20084700.00	20077567.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10207000.00	8942322.43	10736900.00	10118810.62
210201	Тэтгэврийн даатгал	7182700.00	6265900.63	7555300.00	7170581.37
210202	Тэтгэмжийн даатгал	604900.00	729350.95	636000.00	796337.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	756100.00	580067.40	795600.00	630349.18
210204	Ажилгүйдлийн даатгал	151200.00	120623.39	159400.00	123401.27
210205	Эрүүл мэндийн даатгал	1512100.00	1246380.06	1590600.00	1398141.54
2104	Хангамж, бараа материалын зардал	7582900.00	7583000.00	9180900.00	9180900.00
210401	Бичиг хэрэг	1025000.00	1025000.00	994300.00	996700.00
210402	Тээвэр, шатахуун	6157900.00	6158000.00	6253100.00	6253100.00

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	320,000.00	320,000.00	1,310,400.00	1,308,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	50,000.00	448,500.00	448,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,000.00	30,000.00	174,600.00	174,600.00
2105	Нормативт зардал	20,000.00	20,000.00	469,400.00	469,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,000.00	20,000.00	469,400.00	469,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,590,000.00	7,222,500.00	13,022,500.00	5,976,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	632,500.00	8,000,000.00	954,000.00
210604	Урсгал засвар	17,590,000.00	6,590,000.00	5,022,500.00	5,022,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,194,000.00	694,000.00	970,000.00	970,000.00
210702	Дотоод албан томилолт	1,194,000.00	694,000.00	970,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,154,000.00	1,642,240.00	488,900.00	162,115.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-	314,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	136,840.00	145,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	22,000.00	29,100.00	16,615.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,300,000.00	4,763,100.00	47,270,000.00	16,903,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	963,100.00	41,000,000.00	10,633,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,800,000.00	3,800,000.00	6,270,000.00	6,270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	380,000.00	380,000.00	1,368,600.00	1,368,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	380,000.00	1,368,600.00	1,368,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	380,000.00	1,368,600.00	1,368,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,904,400.00	-	37,412,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,904,400.00	-	37,412,900.00
223001	Бусад хөрөнгө	-	13,904,400.00	-	37,412,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	123,034,800.00	117,811,300.00	163,039,600.00	163,039,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	123,034,800.00	117,811,300.00	163,039,600.00	163,039,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	123,034,800.00	117,811,300.00	163,039,600.00	163,039,600.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн байгууллагын дотоод хяналт, шалгалтын ажил хангалтгүй зохион байгуулсан тул зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.01.10-наас 2022.01.17–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.01.17-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.05-ний өдрийн 01/2 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нутгийн өөрийн удирдах ёсыг төлөвшүүлэх, Монгол улсын хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, удирдлагын зөв тогтолцоотой орон нутгийн тогтвортой хөгжлийг хангасан аймгийн жишиг сум болгох “гэсэн зорилт дэвшүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 139.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар төсвийн хөрөнгөөр 37.4 сая төгрөг, 48.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгджээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 21.3 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр бэлтгэж 19.7 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант онд 39,9 мянган төгрөгийн авлагатай байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 5.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан орон нутгийн төсвөөс 163.0 сая төгрөг батлагдаж, 163.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төсвөөс авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар орлого ороогүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 148 мэдээллийг ил тод мэдээлсэн 1 мэдээлэл хугацаа хоцорсон байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөрчил илрээгүй байна.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1545,0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2 албан шаардлага өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа зөрчил гараагүй.

4.2 Зөвлөмж

Санхүү тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	1.5					2	1.5		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Ц.МӨНХЗАЯА

2022 ОНЫ 01 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 01 сарын 01 өдөр

Дугаар ӨВА-2022/155/НА-СТА-ТШЗ/11570351/26 Арвайхээр

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын нарийн бичгийн дарга Ш.Болормаа танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь төсвийн хөрөнгөөр 1045.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, уралдаан тэмцээнд 500.0 мянган төгрөгийн зардлыг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Монгол улсын засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "албан конторын тавилга худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, 1.6 засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." , Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан албан конторын тавилга худалдан авах, уралдаан тэмцээн зохион байгуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ш.Болормаа, нягтлан бодогч Г.Оюун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АУДИТОР  Ц.МӨНХЗАЯА

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ӨВА-2022/155/НА-СТА-ТШЗ

Байгууллагын нэр: Хархорин сумын ИТХ

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл		Шалгагдагч байгууллагын	
							7	8	Албан тушаал	Овог нэр
1	Урсгал зардал	Төсвийн хөрөнгөөр тавилга эд хогшил худалдан авсан	1045.0	албан шаардлага	Санал байхгүй.	Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Монгол улсын засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4 " албан конторын тавилга худалдан авалтыг зохион байгуулахгүй байх	албан шаардлага	8	9	Ш.Болормаа Г.Оюун
2	Урсгал зардал	Уралдаан тэмцээн зохион байгуулсан	500.0	албан шаардлага	Санал байхгүй.	Монгол улсын засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.6 засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх	албан шаардлага	8	9	Ш.Болормаа Г.Оюун

Бэлтгэсэн:

АУДИТОР

Ц.МЭНХВАЯА

Анхан шатанд хянасан

АУДИТЫН МЕНЭЖЕР

Д.ГАНСҮХ

Хоёр дөхө шатанд хянасан

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

Хархорин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга

Ш.БОЛОРМАА

ОЮУН

Нягтлан бодогч



